

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРТ

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн хуралдааны 13 дугаар тэмдэглэлд:

“ҮИИ.2. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, бусад эх үүсвэр, өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх улирлын чанартай төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг 2018 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн байдлаар гарган Сангийн сайд Ч.Хүрэлбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав.


1. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгов:

-улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, бусад эх үүсвэр, өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулж, хуулийн дагуу шалгарсан гүйцэтгэгчтэй 2018 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор гэрээ байгуулж, төсөл, арга хэмжээний ажлыг эхлүүлэх;

-эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу хяналт тавьж ажиллах;

-хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, тайлан мэдээг Сангийн яаманд цаг хугацаанд нь хүргүүлэх.

2. Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын 2017 оны 337 дугаар тогтоолын 1.7 (б) дахь заалтын биелэлтийг 4 дүгээр сарын 1-ний байдлаар гарган Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР